



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/26

Мөрөн сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардуулах 85 ба түүнээс дээш настай ахмадууд, гавьяатууд болон аймгийн Засаг даргын Тамгын газрын ахмад настны нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Гарын бэлэг хүргэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар), Нийтлэг үйлчилгээний алба (Б.Батжаргал) нарт даалгасугай.

3. Арга хэмжээний зардалд шаардагдах 15,000,000 (Арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын "Бусад баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээний зардал"-аас санхүүжүүлж, холбогдох хууль, журмын хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН